



Thomas Jefferson дунд сургууль

IBMYP 11-р сарын сонин



Энэ сарын шилдэг сурагч: ЭРЭН СУРВАЛЖЛАГЧ

Бид бүх сурагчдаа эрэн сурвалжлагчид байгаасай гэж хүсдэг. Манай анги танхимд багш сурагчид хамтран ажиллаж бүх хичээлийн хувьд бодит баримттай холбоотой, онолын болон мэтгэлцэхүйц асуудлыг эрэн сурвалжлагч асуултууд боловсруулдаг. Бид сурагчдаа сониуч зан төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын шинж чанартай зургаан асуулт ашигладаг. Тухайлбал: Бид хэн бэ? Бүх зүйлс хэрхэн холбогддог вэ? Бүтээлч илэрхийллийн зорилго юу вэ?



Манай шилдэг эрэн сурвалжлагч сурагчид: **Далайн гахай - Beckett Hampton, Луу - Carsten Polestak, Бүргэд - Ella Godbout, Матар - Phoebe Schaible, Эрвээхэй - Gloria Fosso, Шар шувуу - Fikir Reta, Оцон шувуу - Ava Fischer, Галт шувуу - Aurnab Barua, болон Далайн муур - Emma Abramson.** Эх сурвалж: pixbay.com

Бичгээр гаргасан сургалтын хөтөлбөр

Энэ сард бид Jefferson сургуульд байдаг манай Тусгай боловсрол болон Унших стратегийн багш нарын удирдан явуулдаг, Fountas & Pinnell нарын бий болгосон Бичиг үсэг тайллын түвшнийг дэмжихүй (LLI) хөтөлбөрийг онцлохыг хүслээ. Энэ бол сурлагын хоцрогдолтой бүх сурагчдад илүү сайн түвшинд уншиж сурахад нь тусалдаг гайхалтай хөтөлбөр юм. Ялангуяа өөрийн ангийн түвшнээс хоёр эсвэл түүнээс дээш түвшин доогуур уншиж байгаа сурагчдад LLI хөтөлбөрийг ашигладаг. Уг хөтөлбөрийн хүрээнд сурагчдыг жижиг бүлэгт (4-6 сурагчтай) хуваан, тэдэнд сонирхолтой, зохих түвшний ном уншуулдаг. Сурагчдад зориулсан түгдрэлгүй унших заавар, системчилсэн авиазүй, хүнд ангиллын ном хурдан унших зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаа, хичээл ордог. Уншлагын түвшин бүрд тохирсон ном, хичээл байдаг бөгөөд тэдгээрийг өнгөөр ялгасан байдаг. Энэ нь бүх сурагчид манай хатуу чанга хөтөлбөрт ороход туслах нэн чухал арга хэрэгсэл юм.

IB хэлний шинэ журам



Манай Jefferson сургуулийн Хэлний журам батлагдлаа. Хоёр гол заалт: Нэгдүгээрт, Jefferson сургуулийн бүх багш харилцан ярианд төвлөрсөн Хэлний багш байна. Хоёрдугаарт, бид бодит баримт, эрх болон нөөцийн хувьд олон хэлний төрөлжсөн сургууль байна. Манай

сурагчид 30 гаруй хэлээр ярьдаг. Гэртээ англи хэлээр ярьдаггүй сурагчид амжилтад хүрэхэд нь туслах дэмжлэг үзүүлэх NILET ангид элсэн ордог. Тэд эх хэл, англи хэл, өөр нэг олон улсын хэлийг сурах эрхтэй. Бид долоон хэл сурахыг санал болгодог. Америкийн дохионы хэл, араб хэл, хятад хэл, франц хэл, латин, испани хэл, чөлөөтэй ярьдаг хүмүүст зориулсан испани хэл.

[Журамтай бүрэн эхээр нь энд танилцана үү.](http://www.ibo.org) Эх сурвалж: pixbay.com

ДБХ-ийн анги ба бодит үнэлгээ

Эхний улирлын төгсгөлд сурагчид бөөн шалгалт, даалгавар, дуусгах төсөлтэй байдаг. Эдгээр цогц үнэлгээ сурагчид маань юу сурсныг ойлгож мэдэхэд чухал үүрэгтэй. Гэхдээ бидний үнэлгээ бодит болохыг бид хэрхэн мэдэх вэ? Дүгнэх үйл явцыг дотооддоо стандартчилах зорилгоор багш нарын баг уулзаж хэлэлцдэг. Түүхийн 6 баг ийм зүйл хийсэн. Багш нар сурагчдын өндөр, дундаж, доогуур түвшний эссэнээс загвар болгон авч дүгнэсэн. Тохиолдол бүрийн ард ямар таамаглал байсныг тодруулж, багш нар дүн бүр дээр рубрик ашиглан бараг л бүрэн санал нэгдсэн. Математикийн 6 баг шалгалтын дүнг эцэслэхдээ ижил үйл явцыг ашигласан. Эх сурвалж: pixbay.com



Олон нийтийн төслийг сурвалжлан судлах

Сурагчид олон нийтийн төслийн дараагийн үе шат болох үйл ажиллагааны санал уруу орж байна. Энэ нь сурагчид маань өөрсдөөс нь маш ихийг шаардсан сорилт бүхий зорилго дэвшүүлж, өөрийн сонгосон олон нийтийн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг тодорхой газар, тодорхой хугацаанд хийхээр төлөвлөх ёстой гэсэн үг.



Цаашилбал манай номын санч хатагтай J Miller-ийн ачаар олон нийтийг хэрэгцээг эрэн сурвалжилж судлах шинэ мэдээлэл аргатай болсон. Тэрээр сурагчдын шийдвэрлэх хүсэлтэй олон нийтийн түгээмэл хэрэгцээний цахим цуглуулгын жагсаалт гаргасан. Тухайлбал: Ядуурал, амьтад, нийгмийн асуудал гэх мэт. [Эндээс илүү мэдээлэл, зургийн эх сурвалжийг хараарай.](http://www.impact.org)

Жефферсоны нэрэмжит сургууль олон нийтэд

Jefferson сургуулийн 8-р ангийнхан Талархлын өдрийн өмнөх Даваа, Мягмар гарагт Ажил мэргэжлийн өдөр болон Коллежид зочлох аялал зэргийг зохион байгуулж, завгүй байлаа. мэргэжлийн өдрөөр манай сурагчид АНУ-ын армийн хурандаагаас эхлээд тогооч хүртэлх 28 мэргэжилтэй хүний яриаг сонссон. Сурагчид маань эдгээр төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээс ухаалаг асуултууд асууж чадсан. Мягмар гарагт бид 8-р ангийн бүх сурагчдыг коллеж уруу дагуулж явсан. Бид Жорж Мейсон, Жоржтаун, Мэрилэндийн их сургууль гэх мэт алдартай есөн сургуулиар зочилсон. Сурагчид маань коллежийн амьдрал ямар байдаг талаар мэдэж авсан. [Зургийн эх сурвалж.](http://www.impact.org)



Ажил ажил

Дэлхий даяарх үйл явц

Jefferson сургуулийн 21 орчим сурагч 11-р сарын 17-ны өдрийн Бямба гарагийг Жорж Вашингтоны их сургуульд хатагтай Miller-ийн ивээн тэтгэсэн НҮБ-ын Загвар уулзалтад оролцож өнгөрүүлсэн. Тэрээр манай сурагчид “Эерэг эрсдэл үүрэгчид байж сайн ажилласан! Мөн Kritika Rai-г магтан сайшаасан” гэж бичсэн. Эх сурвалж: Гэрэл зургийг ноён Malinosky авсан.



Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- Лхагва гараг бүр номын санд олон нийтийн төсөлд туслах
- Мягмар гараг бүр 17:00 цагт дугуй засахад сайнд дураар туслах Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](http://www.impact.org))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлахад сайн дураар туслах AFAC-т, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүй мэдээллийг эндээс аваарай](http://www.impact.org))
- Хоолны автобусны асуудлыг зохицуулах бол ноён [Malinosky](http://www.impact.org)-той холбогдоорой
- [Сайн дурын ажлын хуваарь энд бий.](http://www.impact.org)